



ТЭЭВЭР,

2020 оны эхний хагас жилд

Агаарын тээвэр



	2019 I-VI	2020* I-VI	
Зорчигчид, мян хүн (давхардсан тоогоор)	670.7	291.2	
Тээсэн ачаа, тонн	2 702.0	1 402.4	
Тээврийн орлого, тэрбум төгрөг	209.4	70.7	

Төмөр замын тээвэр



Зорчигчид, мян хүн (давхардсан тоогоор)	1 237.8	892.9	
Тээсэн ачаа, мян.тонн	13 161.4	14 459.5	
Тээврийн орлого, тэрбум төгрөг	336.4	366.2	

Авто замын тээвэр



Зорчигчид, мян хүн (давхардсан тоогоор)	89 156.6	60 619.6	
Тээсэн ачаа, мян.тонн	18 898.0	8 418.0	
Тээврийн орлого, тэрбум төгрөг	335.9	184.8	

*-Урьдчилсан гүйцэтгэлээр



ТЭЭВЭР

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2020 оны эхний хагас жилд 22.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 9.2 (28.6%) сая тонноор буурсан байна. Энэхүү бууралтад авто тээврээр тээсэн ачаа 10.5 (55.5%) сая тонноор буурсан нь голлон нөлөөлжээ.

Бүх төрлийн тээврээр 2020 оны эхний хагас жилд 61.8 сая хүн (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны мөн үеэс 29.3 (32.1%) сая хүнээр буурсан байна. Зорчигчдын тоо буурахад авто тээврээр зорчигчид 28.5 (32.0%) сая хүнээр буурсан нь голлон нөлөөлжээ.

Бүх төрлийн тээврийн үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
	I-VI	I-VI	I-VI	* I-VI
Тээсэн ачаа, сая тонн	28.0	32.5	32.1	22.9
Зорчигчид, сая хүн	106.1	99.4	91.1	61.8
Тээврийн орлого, тэрбум төгрөг	672.8	802.2	881.8	621.7

Бүх төрлийн тээврээр тээсэн ачаа 2020 оны 2 дугаар улиралд өмнөх улирлаас 2.5 (23.9%) сая тонн, зорчигчид 3.6 (12.2%) сая хүнээр өссөн байна.

Бүх төрлийн тээврийн орлого 2020 оны эхний хагас жилд 621.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 260.1 (29.5%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Авто тээврийн орлого 151.1 (45.0%) тэрбум төгрөг, агаарын тээврийн орлого 138.7 (66.2%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь бүх төрлийн тээврийн орлого буурахад нөлөөлсөн байна. Мөн бүх төрлийн тээврийн орлого өмнөх улирлаас 2.1 (0.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

АВТО ЗАМЫН ТЭЭВЭР

Авто тээврээр 2020 оны эхний хагас жилд 8.4 сая тонн ачаа, давхардсан тоогоор 60.6 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 10.5 (55.5%) сая тонн, зорчигчид 28.5 (32.0%) сая хүнээр тус тус буурсан байна.

Ачаа тээврийн бууралтад уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр 9.0 сая тонн буюу 55.9 хувиар, зорчигч тээврийн хувьд нийслэлийн тээврээр зорчигчид (давхардсан тоо)

26.2 (32.1%) сая хүнээр буурсан нь нөлөөлсөн байна. Харин 2020 оны 2 дугаар улиралд, авто замын тээврээр тээсэн ачаа өмнөх улирлаас 2.2 (69.4%) сая тонн, зорчигчид 3.7 (13.0%) сая хүнээр өссөн байна.

Авто тээврийн үндсэн үзүүлэлт


Үзүүлэлт	2017	2018	2019	2020*
	I-VI	I-VI	I-VI	I-VI
Тээсэн ачаа, сая тонн	17.7	20.3	18.9	8.4
Уул уурхайн бүтээгдэхүүн	15.2	17.2	16.1	7.1
Зорчигчид, сая хүн	104.3	97.5	89.2	60.9
Нийслэлийн нийтийн тээвэр	96.6	90.4	81.4	55.2
Тээврийн орлого, тэрбум төгрөг	272.6	332.5	335.9	184.8

Авто тээврийн салбарын орлого 2020 оны эхний хагас жилд 184.8 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 151.1 (45.0%) тэрбум төгрөгөөр буурсан бол өмнөх улирлаас 12.9 (15.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн орлого өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР

Төмөр замын тээврээр 2020 оны эхний хагас жилд 14.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.3 (9.9%) сая тонноор өсжээ.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа, мянган тонн, сараар




Төмөр замын тээврээр тээсэн ачааны өсөлтөд экспортын ачаа 1.2 (25.6%) сая тонн, импортын ачаа 109.2 (8.1%) мянган тонноор тус тус өссөн нь нөлөөлсөн байна төмөр замын тээврээр тээсэн ачаа 2020 оны 6 дугаар сард 2.4 сая тонн болж, өмнөх сараас 87.2 (3.4%) мянган тонноор буурчээ.

Төмөр замаар тээсэн ачаа, бүтээгдэхүүний бүлгээр, дүнд эзлэх хувиар

Үзүүлэлт	2018 I-VI	2019 I-VI	2020* I-VI
Бүгд	100.0	100.0	100.0
Уул уурхайн бүтээгдэхүүн	85.9	84.5	85.8
Барилгын материал	7.5	8.4	7.9
Мод, модон материал	0.5	0.5	0.5
Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн	1.1	1.0	0.9
ХАА-н гаралтай бүтээгдэхүүн	1.0	1.6	1.0
Хар төмөр (хаягдал, рельс г.м)	0.9	1.4	1.5
Бусад	3.1	2.6	2.5

Төмөр замын тээврээр 2020 оны эхний хагас жилд тээсэн нийт ачаанд уул уурхайн бүтээгдэхүүн 85.8 хувь, барилгын материал 7.9 хувь, хар төмөр 1.5 хувь, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн 1.0 хувь, хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн 0.9 хувь, мод модон материал 0.5 хувь болон бусад бүтээгдэхүүн 2.5 хувийг эзэлж байна.

Төмөр замын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар



Төмөр замын тээврээр 2020 оны эхний хагас жилд 892.9 (давхардсан тоо) мянган хүн зорчсон нь өмнөх оны мөн үеэс 344.9 (27.9%) мянган хүнээр буурсан байна.

Төмөр замын тээврээр зорчигчдын тоо буурахад орон нутгийн зорчигчид 306.6 (25.8%) мянган хүнээр буурсан нь нөлөөлсөн байна. Төмөр замын тээврээр зорчигчид 2020 оны 6 дугаар сард 187.6 мянган хүн болсон нь өмнөх сараас 34.9 (22.9%) мянган хүнээр өсжээ.

Төмөр замын тээврийн орлого 2020 оны эхний хагас жилд 366.2 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 29.7 (8.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэ

өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүн, тухайлбал төмрийн хүдэр, жонш, нүүрсний тээвэрлэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврийн орлого 2020 оны 6 дугаар сард өмнөх сараас 1.7 (2.6%) тэрбум төгрөгөөр буурч, 64.3 тэрбум төгрөг болжээ.

Агаарын тээврээр тээсэн ачаа, тонн, сараар



Агаарын тээврээр 2020 оны эхний хагас жилд дотоодод 38.5 (2.7%) тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 0.7 (1.8%) тонноор буурсан байна. Мөн олон улсад тээсэн ачаа 1.4 (97.3%) мянган тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 1.3 (48.8%) мянган тонноор буурчээ.

Агаарын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар



Агаарын тээврээр тээсэн ачаа 2020 оны 6 дугаар сард 105 тонн болж, өмнөх сараас 18.4 (14.9%) тонноор буурсан байна.

Агаарын тээврээр 2020 оны эхний хагас жилд давхардсан тоогоор 291.2 мянган хүн зорчсон нь өмнөх оны мөн үеэс 379.5 (56.6%) мянган хүнээр буурсан байна.

Агаарын тээврээр 2020 оны 6 дугаар сард өмнөх сараас 1.7 (6.8%) мянган хүнээр бага буюу 23.9 мянган хүн зорчсон байна.

Агаарын тээврээр орон нутагт зорчигчид 2020 оны эхний хагас жилд 153.6 (52.8%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 45.4 (22.8%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Чойбалсан чиглэлийн зорчигчид 85.1 хувь, Овоот чиглэлийн зорчигчид 81.7 хувь, Мөрөн чиглэлийн зорчигчид 60.9 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2020 оны эхний хагас жилд 137.6 (47.2%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 334.1 (70.8%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Улаанбаатар- Бээжин чиглэлийн зорчигчид 86.4 хувь, Улаанбаатар-Эрхүү чиглэлийн зорчигчид 80.2 хувь, Улаанбаатар-Гонконг чиглэлийн зорчигчид 76.5 хувь, Улаанбаатар-Хайлаар чиглэлийн зорчигчид 78.6 хувь, Улаанбаатар-Бусан чиглэлийн зорчигчид 76.8 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2020 оны эхний хагас жилд 70.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 138.7 (66.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2020 оны 6 дугаар сард өмнөх сараас 4.2 (2.1 дахин) тэрбум төгрөгөөр өсөж, 8.2 тэрбум төгрөг болсон байна.